

**Эрчимт эмчилгээний эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн
шалгалтын жишиг сорил**

Сорил-1

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (А.)
 - Зөв, Зөв, Буруу (В.)
 - Зөв, Буруу, Буруу (С.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)

Сонгогдсон сорил

/1./ Хэвийн нөхцөлд сийвэнгийн уургийн (коллоид) осмос даралт ямар байх вэ?

- A. 0 ммHg
- B. 5 ммHg
- C. 20 ммHg
- D. 50 ммHg
- E. 100 ммHg

/2./ Гепарины эсрэг протамин хийхэд дараах батламжуудын нэг нь БУРУУ:

- A. Судсанд хийхэд гаж нөлөө, харшлын осол байдаг
- B. Энэ нь нийлэг аргаар хийсэн давс
- C. Анафилаксийн урвал өгдөг
- D. Үүнийг аажим тарих шаардлагатай
- E. Захын венээр хийж болно

/3./ Гипоксийн гаралтай судасны агшилт үүсдэг эрхтэн нь:

- A. Уушги
- B. Тархи
- C. Зүрх
- D. Элэг
- E. Арьс

/4./ Уушгины хаван болгохгүй нөхцөлийг заа

- A. Судасны нэвчилт өөрчлөгдөх
- B. Уушгины капиллярын даралт буурах
- C. Онкос (онкотик) даралт багасах
- D. Амьсгалын замд сорох (сөрөг) даралт үүсэх
- E. Толгойн гэмтэл

/5./ Тосгуур-синусийн (синоатриал) зангилааны өөрөө үүсгэх хэм минутанд хэдэн удаа байх вэ:

- A. 20-40/мин
- B. 40-60/мин
- C. 70-80/мин
- D. 80-100/мин
- E. 100-120/мин

/6./ Гиповолемитай өвчтөнд ажиглагдахгүй нь:

- A. Зүрхний цохилт олшрох
- B. Пульсийн даралт нэмэгдэх

- C. Шээсний гарц багасах
 - D. Хүзүүний венүүд шалчийх
 - E. Салст бүрхүүл цонхийж цайрах
- /7./ Хэт амьсгалуулалт (гипервентиляц) хийхэд титэм судасны цус эргэлт хэрхэн өөрчлөгдөх вэ?
- A. Өөрчлөгдөхгүй
 - B. Цус урсалт ихэснэ
 - C. Цус урсалт буурна
 - D. Түр ихэссэний дараа судас их тэлэгдэнэ
 - E. Судас агшилт эрчимжинэ
- /8./ Сийвэнгийн эзэлхүүн нэмэгдүүлэх үйлчилгээгүй шингэн
- A. Декстранууд
 - B. Сийвэн
 - C. Цус
 - D. 5% глюкозын уусмал
 - E. Өөх тосны эмульс
- /9./ Организмын азотын баланс гэдэг нь
- A. Цусан дахь уургийн ерөнхий хэмжээ
 - B. Хоногт алдаж буй азотын хэмжээ
 - C. Хоол ундтай авч буй азотын хоногийн хэмжээ
 - D. Хоногт авч болон алдаж байгаа азотын харьцаа
 - E. Цусанд агуулагдах мочевины хэмжээ
- /10./ АсАТ/АлАТ-ын харьцаа хэдийд багасах вэ?
- A. Инфаркт
 - B. Гемолиз
 - C. Төрөл бүрийн шалтгаантай зүрхний өвчин
 - D. Төрөл бүрийн шалтгаантай гепатит
 - E. Бөөрний цочмог дутагдал
- /11./ Альбумины шинж чанаруудад хамаарахгүй нь:
- A. Судсанд шингэнийг барьж байх, судсаар урсах шингэнийг ихэсгэх
 - B. Сийвэнгийн коллойд осмос даралтыг барьж байхад чухал үүрэгтэй
 - C. Фермент, гормон, эмийн бодсыг зөөвөрлөхөд оролцдог
 - D. Ийлдсийн гепатит үүсгэж болно
 - E. Организмын уураглаг тэжээлийн үүсвэр болох
- /12./ Уушгины амьдралын багтаамж тооцоолсноос 80%-аас багаар буурах нь юуг харуулах вэ?
- A. Амьсгалын төвийн өөрчлөлт
 - B. Уушгины өвчнүүд
 - C. Амьсгалын замын чөлөөт байдал алдагдах
 - D. Хэвийн үед байж болно
 - E. Солилцоо багассанаас
- /13./ Бүрэн самшуу (parental) тэжээлийн стандарт уусмалуудын найрлагт ОРОЛЦДОГГҮЙ бодис:
- A. Декстроз
 - B. Фосфат
 - C. Өөхний эмульс
 - D. Глютамин
 - E. Цайр (zinc)
- /14./ С гепатит халдаах эрсдэл багатай бэлдмэл:
- A. Криопреципитат
 - B. Шинэ хөлдөөсөн сийвэн
 - C. Даршилсан улаан бөөм
 - D. Угааж хөлдөөсөн улаан бөөм
 - E. 5% альбумин

/15./ Бүрэн (total) самшуу тэжээлд байгаа хүнд элбэг гардаг лабораторийн хэвийн бус үзүүлэлт:

- A. Гипогликеми
- B. Гиперлипидеми
- C. Гиперфосфатеми
- D. Элэгний трансаминаз ихсэх
- E. Гипокальцеми

/16./ Нөөц уутгүй хошуувчаар 5л/мин урсгалаар хүчилтөрөгч өгч байвал FiO_2 хэд орчим байх вэ?

- A. 30%
- B. 40%
- C. 50%
- D. 60%
- E. 70%

/17./ Амь тэнсэж буй өвчтөнд төв венийн гуурсанд халдвар орохоос сэргийлэх:

- A. Арьсыг повидон йодын уусмалаар ариутгах
- B. Үргэлж эгэм доорх венийг сонгож байх
- C. 3 хоноод хөтлүүр ашиглан гуурсаа сольж байх
- D. Гуурс тавьсны дараа антибиотикоор эмчлэх
- E. Гуурс тавихдаа ариун хамгаалалт хийсэн (ариун хошуувч, ариун бээлий, өргөн ариун бүтээлэг) байх

/18./ Өвчтөнийг 100% хүчилтөрөгчөөр амьсгалуулж байхад үүсэх байдал:

- A. Ателектаз устана
- B. Гэдэс дүүрэлт багасна
- C. Үхмэл зай ихэссэнээр PO_2 ихэснэ
- D. Уушгины вентиляц/ перфузийн (V/Q) харьцаа бага байгаа хэсэгт шунт үүснэ
- E. Үйлийн үлдэгдэл багтаамж (FRC) ихэссэнээс хүчилтөрөгчийн даралт ихэснэ

/19./ Гипокальцемитэй хүнд кальц өгөхөд:

- A. Натри бикарбонаттай кальц холилдоно
- B. Хлорид юмуу глюконат хэлбэрээр өгч болно
- C. Гипертензи үүсгэж болно
- D. Судсаар эсвэл булчинд хийнэ
- E. Глюконат давс нь илүү

/20./ Том хүний биеийн шингэн биеийн жинд эзлэх хувь:

- A. 10%
- B. 20%
- C. 30%
- D. 40%
- E. 60%

/21./ Глазгогийн комын үнэлгээний бүрдэл:

- A. Нүд нээх, үг яриан хариулт, хөдөлгөөний байдал
- B. Өвдөгний рефлекс ба бусад хөдөлгөх рефлекс
- C. Хүүхэн хараа ба тархины баганын рефлексүүд
- D. Амьсгал ба тархины баганын автоном хариулт
- E. Тархины цахилгаан бичлэг

/22./ “Torsade de points” нь:

- A. Прокаинамидаар засарна
- B. Ховдлын тахикардийн нэг хэлбэр
- C. QT зай богино байдаг онцлогтой
- D. Магни ихдэлтээс (гипермагнезemi) үүсч болно
- E. Эмэгтэйгээс эрэгтэйд илүү тохиолдоно

/23./ Зүрхний түрэлт (output) БАГАСАХ нь:

- A. Зүрхний цохилт 50-аас 72 болж нэмэгдэх

- B. Өмнөх ачаалал ихсэх
- C. Хожим ачаалал ихсэх
- D. Миокардын өвчнөөс
- E. Дигоксиноос

/24./ Миокардын хүчилтөрөгчийн хэрэглээ (зарцуулалт) хамгийн ихээр шалтгаалах хүчин зүйл нь:

- A. Зүрх цохилтын тоо
- B. Цусны нялзамхай чанар
- C. Зүрхний түрэлт (output)
- D. Цохилтын (агшилтын) эзлэхүүн
- E. FiO_2

/25./ Нас ахих хэрээр зүрх судсанд гарах өөрчлөлт:

- A. Цусны даралт буурах
- B. Зүрх судасны үйлийн нөөц ихсэх
- C. Судасны уян чанар алдагдах
- D. Миофибриллийн тоо нэмэгдэх
- E. Зүрхний түрэлт (output) нэмэгдэх

/26./ АлАТ ихсэх нь ямар үед оношийн ач холбогдолтой вэ

- A. Зүрхний шигдээс
- B. Элэгний цирроз
- C. Булчингийн эмгэг
- D. Гепатит
- E. Гемолиз

/27./ Тархины үхэл тогтооход дараах зүйлсээс аль нь үнэн бэ?

- A. Заавал тархины цахилгаан бичлэг хийнэ
- B. Децеребрац байхад нугасны рефлекс хадгалагддаг
- C. Тархины гадар үхвэл тархи үхсэн байна
- D. Биеийн дулаан $350C$ -ээс бага байвал тархины үхэл шалгах сорил хийж болохгүй
- E. Апноэ сорил хийхэд $PaCO_2$ -ыг $7,5kPa$ / $56mm.mub$ / хүргэх хэрэгтэй

/28./ Тромбоцитопени ямар эмгэгийн үед үүсэх вэ

- A. Түлэгдэл
- B. Гемолиз
- C. Пневмони
- D. Верльгофын өвчин
- E. Булчингийн гэмтэл бяцрал

/29./ Гипертоник гипергидрацийн үед илрэхгүй шинж:

- A. Ам цангах
- B. Хаван
- C. Сийвэнгийн осмос ихсэх
- D. Сийвэнгийн осмос чанар буурах
- E. Мэдрэл сэтгэцийн өөрчлөлт

/30./ Даралтаар дэмжих амьсгалын амьсгал оруулалт төгсөх нь:

- A. Тохируулсан хугацаа дуусахад
- B. Тогтоосон амьсгалын эзлэхүүн орж гүйцэхэд
- C. Тогтоосон даралтын түвшинд хүрэхэд
- D. Урсгал нь оргил хэмжээнээсээ 25% -иар буурахад
- E. Амьсгалын багтаамжид хүрэхэд

/31./ Пропранололоор эмчлэгдэх нь:

- A. Синусийн брадикарди
- B. Архаг бронхит
- C. II хэлбэрийн чихрийн диабет
- D. Тосгуур-ховдлын (AV) хориг
- E. Тосгуурын жирвэлзэл

/32./ Олон хавирга хугарч гэмтсэн өвчтөнд интубац хийж амьсгалын дутагдлаас гаргахаар удирдлагат механик амьсгал, РЕЕР-тэй явуулсан. Интубацын дараа өвчтөний ЦД буурсан бол авах арга хэмжээ:

- A. Цээжний зураг яаралтай авах
- B. Шингэн сэлбэх
- C. Үнхэлцэг хатгах
- D. 100% хүчилтөрөгчтэй гипервентиляц хийх
- E. Торакотоми хийж аорт хавчих

/33./ Хиймэл амьсгалуур (интубац, трахеостоми г.м) тавьсан хүнд соруулалт хийх тухайд БУРУУ зааварчлалыг заа:

- A. Тогтмол давтамжаар төлөвлөж үргэлж соруулж цэвэрлэнэ
- B. Брадикарди үүсгэж болно
- C. Гипоксеми болгох үндэстэй
- D. Амьсгалын салст гэмтээх осолтой
- E. Ателектаз үүсгэж болно

/34./ Эс дотор зонхилох ион:

- A. Na+
- B. K+
- C. Cl+
- D. HCO₃⁻
- E. Mg⁺⁺

/35./ Криопреципитатад байдаггүй бүлэгнүүлэх хүчин зүйл:

- A. VIII фактор
- B. IX фактор
- C. XIII фактор
- D. Фон Уилебранд хүчин зүйл
- E. Фибриноген

/36./ Зүрхний 2-р авианд давхцах ХАМААРАЛГҮЙ нь:

- A. Аортын хавхлага хаагдах
- B. Миокардын ширхгүүд жигд сулрах
- C. Митрал хавхлага хаагдах
- D. ЗЦБ.ийн Т шүд
- E. Уушгины хавхлага хаагдах

/37./ Гарыг тосгуурын түвшинд байрлуулсан үед харьтын дунд (median basilic) венийн даралт:

- A. Баруун тосгуурын даралттай тэнцүү
- B. Баруун тосгуурын даралтаас их
- C. Баруун тосгуурын даралтаас бага
- D. Цусны эзлэхүүнээс хамаарна
- E. Гарын байрлал нөлөөлөхгүй

/38./ Агшилтын (SV) эзлэхүүн нь ямар үйлчлэлийн үр дүн болж илрэх вэ?

- A. Миокардын булчингийн ширхэг богиносох
- B. Зүрхний цохилтын тооны
- C. Захын эсэргүүцэл нэмэгдэх
- D. Артерийн хүчилтөрөгч агууламж
- E. Сийвэнгийн калийн түвшин

/39./ Төв венэд гуурс тавих заалтад үл хамаарах нь:

- A. Хагалгааны үед жир биш байрлалд (ж: Трендленбург) оруулах
- B. Өвчтөн шоктой байх
- C. Тэжээл их хийх хэрэгтэй болох
- D. Судсанд вазопрессор эм хийх
- E. Шингэн сэлбэлт ихдэх магадлалтай үе

/40./ АсАТ ихсэх нь ямар үед оношийн ач холбогдолтой вэ?

- A. Баруун зүрхний дутагдал
- B. Тархи бөөрний эмгэг

- C. Булчингийн эмгэг
 - D. Зүрхний шигдээс
 - E. Гемолиз
- /41./ Изотоник дегидратацийн клиник шинж болохгүйг нь заа
- A. Олигури
 - B. Артерийн даралт багасах
 - C. Гиповолемийн шок
 - D. Полиури
 - E. Реакци удаашрах, идэвхгүй болох
- /42./ Бөөрний дутмагшилтай өвчтний:
- A. Өөх тосонд уусах бодис элгээр ялгардаг
 - B. Уреми нь фармакодинамикт нөлөөгүй
 - C. Цусны эзэлхүүн голдуу буурсан байдаг
 - D. Уурагтай нэгддэг эмийн чөлөөт хэсэг их болдог
 - E. Цусны стандарт бикарбонат хэвийн
- /43./ Сорогдлын пневмонит
- A. Хоол сойсон үед тохиолдохгүй
 - B. Эмнэлгээс гадуур нөхцөлд үүсгэгч нь голдуу холимог байдалтай
 - C. Рентгений өөрчлөлт 4-6 цаг дотор харагдана
 - D. Амьсгалын замд $\text{pH} < 7.35$ орчинтой зүйл ороход үүсэх магадлал их
 - E. Хүчилтөрөгчийн хэрэгцээгүй байх
- /44./ Гиперкалиемийн үед илрэх шинж
1. Бөөлжих, гүйлгэх
 2. Аритми, ховдлын экстрасистол
 3. Ховдлын жирвэлзэл
 4. Булчин сулрах
 5. Астенизаци
- /45./ Хлорт Са судсаар хийхэд ямар хүндрэл гарч болох вэ?
1. Артерийн даралт ихсэх
 2. Зарим булчин татах
 3. Зүрх диастолын үедээ зогсох
 4. Зүрх систолын үедээ зогсох
 5. Таталдах
- /46./ Архины үүдэлтэй элэгний өвчин:
1. Хоолны дэглэмээр сэргийлж болно
 2. Нойр булчирхайн өөрчлөлттэй хавсардаг
 3. Гематологийн өөрчлөлт байдал тохиолдохгүй
 4. Витамин дутал голдуу тохиолдоно
 5. Ходоод гэдэсний ямар нэг өвчин хавсардаггүй
- /47./ Омепразол:
1. Ходоодны агуулагдахууны хэмжээг багасгана
 2. Ходоодны хүчлийн шүүрэл багасгана
 3. Ходоод сулрахыг түргэсгэнэ
 4. Цитохром P450-аар зарим эмийн хувирлыг саатуулна
 5. Эдгээр бүгд зөв
- /48./ Өмнөх ачаалал (preload)-д нөлөөлөх зүйлс:
1. Цусны ерөнхий эзлэхүүн
 2. Зүрхний цохилт олшрох
 3. Тосгуурын чадавх
 4. Венийн чалх (тонус)
 5. Уушгины артерийн даралт
- /49./ Гипервентиляцын нөлөө:
1. Тархины судас тэлэх
 2. Таталт болох
 3. Оксигемоглобины муруй баруун тийш хэлбийх

4. Зүрхний түрэлт (output) буурах

5. Зүрхний түрэлт ихсэх

/50./ Хоёр хөлийн шилбэний хугаралтай шокийн байдалтай өвчтөнг эмнэлэгт авчирсан. Энэ үед зайлшгүй авах арга хэмжээ нь:

1. Цус алдалтыг зогсоох /даралтат боолт/

2. Хөдөлгөөнгүй болгох /чиг тавих/

3. Шингэн сэлбэх

4. Өвдөлт намдаах

5. Түргэн тусламжийн сэхээн амьдруулах тусгай хэсгийг дуудах

/51./ Маннитол ямар хэсгийн эзлэхүүн багасгаж ГДД бууруулдаг вэ?

1. Венийн цус

2. Тархины бодис

3. Артерийн судас дахь цус

4. Тархины эд доторх ус

5. Эдгээр бүгд

/52./ Эрчимт эмчилгээний өвчтөнд седац хийх нь:

1. Ухаан самуурал догшрол намдаах

2. Эмчилгээний сэтгэцэд нөлөөлөхийг багасгах

3. Өвдөлт намдаалтын хүчийг нэмэгдүүлэх

4. Седацийн үр дүнг даралт, пульсын тоогоор хэмжинэ

5. Дархлааны хариултад огт нөлөөлөхгүй

/53./ Эмийн ялгаралт (clearance):

1. Идэвхгүй бүтээгдэхүүн болж хувирснаас хамаарна

2. Идэвх багатай бүтээгдэхүүн үүссэнтэй холбоотой байж болно

3. Эм өөрчлөгдөлгүй ялгарснаас хамааралтай

4. Эмийн өтгөрөлөөс хамаардаггүй

5. Эдгээрийн аль нь ч хамаарахгүй

/54./ Чийглэж тоосруулсан хийгээр амьсгалуулах эмчилгээний дүнд гарах өөрчлөлт:

1. Уушгид халдвар орох

2. Өвчтөн дулаан алдах

3. Шингэний ачаалал болох

4. Амьсгалын замын эсэргүүцэл ихсэх

5. Амьсгалын замын эсэргүүцэл буурах

/55./ Төв венийн даралтын гуурсны үзүүрийн байршлыг тодорхойлох:

1. Хэрэв гуурс тосгуурын ханыг түлхвэл электрокардиографид том P шүд гарна

2. Рентген шинжилгээ

3. Даралт хэмжих

4. 1мл агаар хийгээд Допплераар ажиглах

5. Тодруулагч бодис шахаж зураг авах

/56./ Инвазив аргаар цусны даралт хэмжих:

1. A.radialis дээр тавихад тохиромжтой

2. Залгах гуурс хэт урт байвал алдаа гарна

3. Залгах гуурсыг ба мэдрэгчийг угаах систем шаардлагатай

4. Цусны даралтыг зүрхний цохилт бүрээр ба дундаж даралтыг үзүүлнэ

5. Манжетаар даралт хэмжигдэхгүй үед хэрэглэнэ

/57./ Кали дутагдахад илрэх үндсэн шинж юу вэ?

1. Астенизаци

2. Булчин сулрах

3. T шүдний үргэлжлэх хугацаа богиносч, QRS-T уртсана

4. Бөөлжилт

5. Таталт

/58./ Шахсан пневмоторакс:

1. Пневмоторакс жижиг байвал дахин, дахин зураг авч болно
2. Эерэг даралттай вентиляцияас үүсч болно
3. Плеврийн доторх даралт атмосферийн даралтаас бага байхад үүсч болно
4. Гипотензи үүсгэж болно
5. Цээжний рентген хийсний дараа гуурс тавихыг шийднэ

/59./ Эгэмний доорх венд хатгалт хийх цэгүүд:

1. Эгэмний дунд болон дотор 1/3-ын зааг тушаа эгэмнээс 1см доор
2. Эгэмний дунд шугамаар эгэмээс 1 см доор
3. Өвчүүний ирмэгээс 2 см зайд, эгэмнээс 1см доор
4. Дохих булчингийн араар өвчүүний чигт
5. Гадна гүрээний венийн доод ирмэгт

/60./ Маннитол:

1. Түүдгэнцрээр шүүгдэнэ
2. Электролит биш
3. Фармакологийн инерт чанартай (идэвхгүй)
4. Бараг бүгдээрээ бөөрний сувганцарт эргэн шимэгдэнэ
5. Сул хүчлийн чанартай

/61./ Пульсгүй цахилгаан идэвх үүсэх шалтгаанд:

1. Уушгины эмболизм
2. Миокардын шигдээс
3. Шахсан (хүчдэлт) пневмоторакс
4. Тосгуурын чичиргээ (Flutter)
5. Тосгуурын жирвэлзэл

/62./ Системийн судасны эсэргүүцэл тооцоолоход орох үзүүлэлт:

1. Артерийн дундаж даралт
2. Төв венийн дундаж даралт
3. Зүрхний түрэлт (output)
4. Уушгины артерийн даралт
5. Уушигны артерийн мухрын даралт

/63./ Бөөрний архаг дуталтай өвчтөнд байдаг өөрчлөлт:

1. Цусны бүлэгнэлтийн хугацаа уртсах
2. Цус багадалт
3. Гиперкалеми
4. Гиперфосфатеми
5. Креатинин ихсэх

/64./ Зүрхний индекс:

1. Зүрхний цус түрэлт (output)-тэй адил
2. Зүрхний түрэлтийг өвчтөний биеийн жинд хувааж тооцно
3. Том хүнд хүүхдийнхээс бага
4. Өвчтөний биеийн хэмжээгээр тооцоолж гаргах нь илүү зөв
5. Зүрхний индексийг тодорхойлоход агшилтын эзэхүүн, минутын эзэлхүүн, биеийн жин, өндөр, зүрхний цохилтын тоо гэсэн 5 үзүүлэлтүүдийн аль нэгийг харгалзахгүйгээр тодорхойлж болно

/65./ Тархины үхэл гэсэн онош тавихад:

1. Тархины эргэлтгүй өөрчлөлтөд орсон шалтгаан ач холбогдолтой
2. Гипонатреми байхгүй байх
3. Гипотензи байхгүй байх
4. РаСО₂-ын түвшин их өндөр байх
5. Хүүхэн хараа өргөсч хөдөлгөөнгүй болоод амьсгалыг зохиомлоор удирдаж байвал

тархины үхэл гэнэ

/66./ Элэгний эмгэгийн Чайлд В ангилал:

1. Альбумин 3.0-3.5 г/дл
2. Билирубин 2.0-3.0 мг/дл
3. Асцит арилдаг
4. INR 2-оос бага

5. Элэгний энцефалопатигүй
- /67./ Зүрх-амьсгалын амилуулалт амжилттай болсны дараа ховдлын жирвэлзэл дахихад хийх эмчилгээ:
1. Вазопрессин
 2. Хоёр фазат дефибрилляц
 3. Амiodарон
 4. Эпинефрин их (0.1мг/кг) тунгаар хийх
 5. Эхний сонголт нь лидокаин байдаг
- /68./ Бронхоспазмын үед илрэх шинжийг заа:
1. Амьсгалын агаарын урсалт саарах
 2. Хөхрөх
 3. Амьсгал гаргалт хэцүү
 4. Хүзүүний вен өргөсөх
 5. Тахикарди
- /69./ Морфины хамааралтай хүн 12 цагийн турш хэрэглээгүй бол үгүйлэх шинж:
1. Чичрэх
 2. Хөлрөх
 3. Татах
 4. Шүлс ихсэх
 5. Пиломотор идэвх (галууны арьс) илрэх
- /70./ Верапамилын нөлөөгөөр ихсэж болох нь:
1. Синус сулралын хамшинж
 2. Тосгуур-ховдлын хориг
 3. WPW хамшинж
 4. Зүрхний зогсонги дутал
 5. Титэм судасны цусан хангамжийн дутагдал
- /71./ Амьсгал гаргалтын төгсгөлд эерэг даралт (PEEP) өгөх нь:
1. Амьсгал гаргалтын дараах багтаамж (FRC) ихэснэ
 2. Вентиляц/перфузийн (V/Q) харьцаа ихэснэ
 3. Уушгины хөшүүн (lung compliance) чанар ихэснэ
 4. Хүчилтөрөгчжилтийг ямагт ихэсгэнэ
 5. Харимхай чанар(elastic recoil) нэмэгдэнэ
- /72./ Цулцангийн хана наалдахгүй байхад юу нөлөөлдөг вэ?
1. Амьсгалын эсэргүүцэл
 2. Уушгины завсрын эд
 3. Плеврийн хөндийн хасах даралт
 4. Сурфактант
 5. Агаарын азот
- /73./ Пульсоксиметр:
1. Бийр (Beer)-ийн хуульд үндэслэсэн
 2. Оксигемоглобиныг ялгаж танина
 3. Метгемоглобиныг оксигемоглобинаас ялгахгүй
 4. Карбоксигемоглобинийг оксигемоглобинаас ялгахгүй
 5. Улаан гэрлийн ганц долгион ашиглана, хэт улаан туяаны долгион ашиглахгүй
- /74./ Цус багадалтын үед:
1. Титэм судасны цус урсах хурд ихэснэ
 2. CO₂-ын байдлаас үүсэх рН-ийн өөрчлөлтийг ээнэгшүүлэх буферийн эзэлхүүн буурна
 3. Хүчилтөрөгчийн зарцуулалт ихэснэ
 4. Хүчилтөрөгчийн диссоциацийн муруй зүүн тийш хэлбийнэ
 5. Шээс үүсэлт буурна
- /75./ Эсээс натри ялгарах, эс дотор кали орох идэвхтэй механизм нь:
1. Эрчим шаардахгүй идэвхгүй процесс
 2. Эсийн мембранд явагддаг
 3. Натрийн өтгөрлөөс хамааралгүй явагдана
 4. Натри, калийн шахуургаар гүйцэтгэгдэнэ

5. Зөвхөн калийн өтгөрөлтэй хамааралтай
- /76./ Зүрх чихэлдлийн (tamponade) шинж:
1. Амьсгаадах, хэвтэхэд дордох
 2. Тахикарди
 3. Гипотензи
 4. Зүрхний авиа чангарах
 5. Гипертензи
- /77./ Зүүн, баруун титмийн артериуд нь:
1. Хоёулаа баруун ховдолд цутгаж орно
 2. Баруун артер баруун ховдлыг тэжээнэ
 3. Эдгээр нь, цус хангах хэсгээрээ ялгарахгүй
 4. Зүүн нь зүүн уруудах ба тойрох артер болж салдаг
 5. Титмийн ерөнхий артери гэж байдаггүй учир 2 артери зэрэг бөглөрөх тохиолдол байдаг
- /78./ Альбумин:
1. Нярайд бага байдаг (харьцангуй)
 2. Сийвэнд хамгийн их байдаг уураг
 3. Сийвэнгийн онкос даралтанд чухал нөлөөтэй
 4. Хагас задрал нь 3 долоо хоног
 5. Элэгний үйлийн хямралтай холбоотой буурна
- /79./ Гемийн гипокси ямар үед үүсэх вэ
1. Анемийн үед
 2. СО хордлогын үед
 3. Ихээхэн гемолизын үед
 4. Капилляр нэвтлэх солилцоо хямрах
 5. Коллапсын үед
- /80./ Аэролзолоор (утлагаар) өгдөг холимог (racemic) эпинефрин нь:
1. Бронход нөлөөлөхгүй
 2. Хавангийн эсрэг үйлдэлтэй
 3. Салст бүрхүүл хавагнуулна
 4. Зөөлөн бронх өргөсгөгч
 5. Эпинефрин ба норэпинефриний холимог
- /81./ Эгэмний доорх венд катетр тавьж болохгүй үе:
1. Дээд хөндийн венийн хам шинж
 2. Цус бүлэгнэлтийн системийн өөрчлөлт
 3. Эгэм орчмын гэмтэл
 4. Шокийн байдал
 5. Зүрхний гаралтай уушгины хаван
- /82./ Нифедипин:
1. Цусны даралт бууруулна
 2. Рефлексээр тахикарди үүсгэж болно
 3. Хэм алдалт эмчлэхэд тохиромжгүй
 4. Зарим өвчтөнд тахикарди үүсгэнэ
 5. Титэм судас нарийсгана
- /83./ Аденозин:
1. Хүний бодисын солилцооны үед үүсдэг
 2. Титэм судасны урсгалыг зохицуулдаг
 3. Тосгуур-ховдлын (AV) дамжуулалтыг удаашруулна
 4. β -адрен агонист мөн
 5. Катехол-О-метилтрансферазаар задардаг
- /84./ Дигоксин:
1. Натри-кали аденозин трифосфатаар идэвхжинэ
 2. Тосгуур ховдлын дамжилтыг сааруулна
 3. Эс доторх Кальцийн түвшинг бууруулна
 4. Агшилт сайжруулна

5. Ховдлын дээрх тахикарди үүсгэнэ
- /85./ Диабетийн комтой өвчтөнд калийн уусмал хэрэглэхдээ юуг анхаарах вэ?
1. Калийг мониторийн хяналттайгаар хэрэглэнэ
 2. Хүн бүрт тохирсон тунг сонгоно
 3. Калийг судсаар хийхдээ 20ммоль/цаг хурдтай хийнэ
 4. Анури, олигуритай өвчтөнд хэрэглэнэ
 5. Хоногийн доод тун нь 750-850 ммоль байна
- /86./ Миокардын агших чадварт нөлөөлөх хүчин зүйл:
1. Франк – Старлингийн механизм
 2. Катехоламины түвшин
 3. Гипокси
 4. Гиперкалиеми
 5. Титэм судасны цусан хангамж
- /87./ Эсийн гаднах шингэн алдагдах нь:
1. Нарийн гэдэсний түгжрэл
 2. Түргэн үүсч буй асцитийн үед
 3. Түлэгдэл
 4. Халуурах, хэт амьсгаадах (гипервентиляц)
 5. Их хэмжээний суулгалт
- /88./ РЕЕР өгөхөд хүчилтөрөгчжил нэмэгдэх учир нь:
1. Амьсгалын зам хаагдалтаас сэргийлэх
 2. Шалчийсан цулцангуудыг тэнийлгэх
 3. Уушгины судасны гаднах шингэний дахин хуваарилагдалд нөлөөлөх
 4. Зүрхний түрэлтийг (output) багасгах
 5. Эдгээр бүгд зөв
- /89./ Төв венэд даралт (ТВД) үзэх гуурс тавихад:
1. Хүзүүний зүүн талын хүрцийг илүү гэж үзнэ
 2. Агаарын эмболи болох осолтой
 3. Үзүүр нь баруун тосгуурт байрлах ёстой
 4. Гүрээний өнгөц болон гүн венийн хүрц нь олон хүндрэлээс сэргийлнэ
 5. Баруун эгэмэн доорх, эсвэл баруун гүрээн гүний венийг сонгосон бол толгойг зүүн тийш сайтар хазайлгана
- /90./ Тулай (gout) өвчинтэй хүнд зохисгүй нь:
1. Циклооксигеназын (СОХ) ингибитор
 2. Сукцинилхолин
 3. β -адренэрг антагонист
 4. Гиповолеми
 5. Индометацин
- /91./ Гүрээний дотор венд хатгалт хийх, катетер тавих үед ямар хүндрэл гарч болох вэ?
1. Гавал тархины IX-XI хос мэдрэл гэмтэх
 2. Гүрээний артери гэмтэх
 3. Пневмоторакс
 4. Дууны холбоо саажих
 5. Гематом үүсэх
- /92./ Механик вентиляцын үед өвчтөнд грам сөрөг савханцрын халдвар үүсгэсэн байх эрсдэлтхүчин зүйлс:
1. Чийглэгч бохирдсон
 2. FiO2 их байх
 3. Өвчтөний хамгаалах чадавх
 4. Ранитидинээр эмчлэх
 5. Аспирац
- /93./ Цочмог цус алдалтын шинжүүдэд хамаарахгүй нь:
1. Судасны лугшилт сул байх
 2. Артерийн даралт унах
 3. Толгой эргэх, сульдах, ухаан балартах

4. Арьс салст хөхрөх
 5. Гар хөлийн үзүүр хөхрөх
- /94./ Эмийн бодис биеэс ялгарах
1. Хуваарилагдахаасаа түргэн
 2. Метаболизмын замаар явагдах
 3. Хагас задралын 2 хугацаа дуусахад төгсөнө
 4. Шүүгдэж гарах байдлаар ялгарч болно
5. Метаболизмаас хамаарахгүй
- /95./ Норэпинефрин:
1. Тирозины бүтээгдэхүүн (дериват)
 2. MAO нөлөөгөөр идэвхгүйждэг
 3. Синапсийн завсраас идэвхтэйгээр гардаг
 4. Капиллярт нөөцлөгдөж болно
 5. Никотины авуурт нэгддэг
- /96./ Зүрхний агшилтын (stroke) эзлэхүүнд нөлөөлөх нь:
1. Өмнөх ачаалал (preload)
 2. Дараах ачаалал
 3. Миокардын агших чадвар
 4. Зүрхний цохилтын тоо
 5. Амьсгалын тоо
- /97./ Зүүн талын эгэмний доорх венд хатгалт хийх үед гарч болох хүндрэлүүд:
1. Агаарын эмболи
 2. Гемоторакс болон пневмоторакс үүсэх
 3. Цээжний лимфийн судас хатгагдах
 4. Эгэмний доорх артер хатгагдах
 5. Уушгины хаван
- /98./ Артерийн даралт ихсэлтийн кризийн үед зайлшгүй хэрэглэх нь:
1. Ганглиолитик
 2. Шээс хөөх эм
 3. Тайвшруулах бэлдмэл
 4. Тайван байлгах
 5. Нитропруссид
- /99./ Үжлийн үеийн гипергликемид нэрмэх хүчин зүйлс:
1. Эпинефрин
 2. Кортизол
 3. Глюкагон
 4. Тироид даавар (Т3)
 5. Эдгээр бүгд
- /100./ Гуурсан хоолойн агшилтын үед хэрэглэдэг нь:
1. Гуурсан хоолойн агшилт тавиулах эмийг судсаар эсвэл цацлагаар хэрэглэх
 2. Гистанины эсрэг эм
 3. Зохиомол амьсгал
 4. Хүчилтөрөгч эмчилгээ
 5. Регидратац хийх
- /101./ Цус сэлбэлтийн гипокальцеми:
1. Хэт түргэн сэлбэлтээс
 2. Бүлээн цус хэт хурдан сэлбэхэд
 3. Гипотермийн үед их байна
 4. Эмчилгээ шаардагдахгүй
 5. Эмнэлзүйд ач холбогдолгүй
- /102./ Уушгины хаван үүсгэх хүчин зүйлс:
1. Капиллярын даралт ихсэх
 2. Онкотик даралт буурах

3. Лимфийн урсгал саатах
 4. Капиллярын нэвчилт ихсэх
 5. Хэт их шингэн сэлбэх
- /103./ Зүрхний цахилгаан бичлэгийн тусгалын электродын байрлал:
1. I тусгал нь зүүн гар ба баруун гарын дохио бичнэ
 2. II тусгал нь ЗЦБ-ийн зүүн гар-зүүн хөлийн дохио бичнэ
 3. V6 тусгал нь зүүн суганы дунд шагамаар 5-р хавирга завсарт байрлуулсан нэг туйлт электродоос бичнэ
 4. V1 тусгал нь өвчүүний баруун захад 2-р хавирга завсарт байрлана
 5. V1 тусгал нь өвчүүний баруун захад 6-р хавирга завсарт байрлана
- /104./ Ямар үед суурийн илүүдэл үүсдэг вэ?
1. Ходоодны агууламжийг байнга соруулах
 2. Сийвэнд хлорын түвшин буурах
 3. Шээс их хөөх
 4. Гипервентиляци
 5. Глюкозын гипотоник уусмал судсаар хийх
- /105./ Завсарлагат албадмал вентиляц (IMV):
1. Өвчтөний өөрийн амьсгал бага зэрэг сэргэсэн байдаг
 2. Урьдчилан тогтоосон тоогоор минутын амьсгал өгнө
 3. Өвчтөний өөрийн амьсгалаас бүрэн хамааралгүй амьсгалуулна
 4. Туслах (assist) вентиляцтай адил
 5. Өдөөгч(trigger)-ийг тохируулж өгнө
- /106./ Уушгины гиповентиляцийн үндсэн шалтгааныг заа:
1. Амьсгал зохицуулалтын төвийн механизм дарангуйлагдсан
 2. Амьсгал зохицуулалтын захын механизм дарангуйлагдсан
 3. Цээжний хэнхэрцгийн хөдөлгөөн хязгаарлагдах
 4. Уушгины хөдөлгөөн хязгаарлагдах
 5. Амьсгалын замын бөглөрөл
- /107./ Дигоксины хордлогын илрэл:
1. P-R зай уртсах
 2. Дотор муухайрах, бөөлжих
 3. Ховдлын олон голомтот экстрасистол
 4. Нүд бүрэлзэх
 5. Тахикарди
- /108./ Амьсгал гаргалтын төгсгөлд эерэг даралт (PEEP) өгөх тохиромжтой хэмжээг тогтоох нь юунаас хамаарах вэ?
1. Гипоксемийн зэрэг
 2. Уушгины өвчний байдал
 3. Уушгины усны хэмжээ
 4. Зүүн ховдлын ажиллагааны байдал
 5. Эргэлдэх цусны эзлэхүүн
- /109./ Гистамин цусанд ихсэхэд:
1. Цус эргэлтэнд гипоксиүүсэхгүй
 2. Уушгины судасны агшилт үүснэ
 3. Гуурсан хоолой тэлнэ
 4. Нийт судас (системийн) тэлэгдэнэ
 5. Нийт судас (системийн) агшина
- /110./ Уушгины амьдралын багтаамж юунаас хамаарах вэ?
1. Биеийн өндөр
 2. Биеийн жин
 3. Уушгины өвчин
 4. Биеийн температур
 5. Анеми
- /111./ Уушгины бөглөрөлт өөрчлөлтөнд хүргэдэг шалтгаан:
1. Цэрний реологи алдагдах

2. Ларингоспазм
 3. Бронхиолын салстын хаван ба спазм
 4. Сурфактант багасах
 5. Уушгины завсрын эдийн хаван
- /112./ Вентиляторын үүдэлтэй пневмонийн тухайд дараах батламжуудаас 3ӨВ нь:
1. Үхлийн хувь 5%-иас бага
 2. Ходоодны агуулагдахуунаар аспирац болох нь элбэг
 3. Антибиотикийн сэргийлэлт үр дүнтэй
 4. Ор, дэрний толгойг өргөж дээр байрлуулах нь сэргийлэх сайн арга
 5. Чийглэсэн хий бохирдох нь халдварын гол эх үүсвэр болно
- /113./ Гипоксийн үед илрэх шинжийг заа:
1. Сэтгэцийн хөөрөл
 2. Тахипноэ
 3. Тахикарди
 4. Тархины хаван
 5. Уушгины хаван
- /114./ Амьдралын багтаамжид ордог бүрдэл:
1. Амьсгалын (tidal) эзлэхүүн
 2. Амьсгал оруулалтын нөөц эзлэхүүн
 3. Амьсгал гаргалтын нөөц эзлэхүүн
 4. Үйлийн үлдэгдэл багтаамж
 5. Эдгээр бүгд
- /115./ Амьсгалын даралт нь:
1. Синус тосгуурын (SA) зангилааны дарангуйлал
 2. Тосгуурын жирвэлзлийн үед ховдлын агшилт цөөрүүлнэ
 3. Олон хэлбэрт ховдлын тахикардийг аажуусгана
 4. Судас нарийсгана
 5. АД ихэсгэнэ
- /116./ Амьсгал гаргалтын эерэг даралт (PEEP) нь:
1. Үйлийн үлдэгдэл багтаамж (FRC)-ийг ихэсгэнэ
 2. Амьсгалын ажлыг багасгана
 3. Уушгины эзлэхүүнийг нэмэгдүүлнэ
 4. Тэлэх чанар бууруулна
 5. Уушгины эзлэхүүнийг багасгана
- /117./ Зүрхний гаралтай уушгины хавангийн эмчилгээ:
1. Гормон
 2. Шээс хөөх эм
 3. Амьсгалын төгсгөлд даралттай амьсгал
 4. Хөөс дарагч, O₂
 5. Ганглиолитик
- /118./ Вольф-Паркинсон-Уайт (WPW) хамшинж:
1. Синус хэмийн үед зүрх цохилт голдуу 60-80 байдаг
 2. Синус хэмтэй үед PR зай 0.12 сек-ээс бага байна
 3. QRS нь голдуу 0.12 сек-ээс өргөн байна
 4. QRS-ийн өгсөх хэсэг голдуу алцайна
 5. Хүнд хэлбэрийн зангилааны (AV) тахикарди үүсгэнэ
- /119./ Хүчдэлтэй /tension/ пневмотораксын үед зайлшгүй шаардлагатай нь:
1. Цээжний гялтангийн хөндийг хатгах
 2. Хүчилтөрөгч эмчилгээ
 3. Зохиомол амьсгал
 4. Зүрхэнд нөлөөлөх бэлдмэл хэрэглэх
 5. Судас нарийсгагч хэрэглэх
- /120./ Чихэргүй диабет(insipidus)-ын шинж:
1. Сийвэнгийн натри их
 2. Сийвэнгийн осмолял чанар их

3. Шээс их шингэн байна
4. Ам цангах шинжгүй байж болно
5. Их шээнэ

/121./ Даралт дэмжлэгтэй (pressure support) вентилияц нь:

1. Даралт хязгаартай-хугацааны циклтэй вентилияц юм
2. Даралт хязгаартай - урсгал циклтэй вентилияц юм
3. Туслах (assist) хэлбэрийн амьсгалаас илүү амьсгалын ачааллыг нэмэгдүүлнэ
4. Өвчтөний уушги тэлэлтээс шалтгаалах амьсгалын эзлэхүүн өгдөг
5. Урьдчилан тогтоосон эзлэхүүнд хүрмэгц амьсгал оруулалт зогсдог

/122./ Кальцийн бэлдмэл хийхэд:

1. Миокардын агшилт суларна
2. Миокардын сэрэх чанар буурна
3. Кальцийн нэгдмэл (хелат) бэлдмэлтэй антгонист боловч клиникт хэрэглэхэд үйлдэл

нь уртасна

4. Дигоксины хорт нөлөөллийг ихэсгэж болно
5. Хэм алдагдлын үед ЗЦТ буурна

/123./ Гиперкалемийг эмчлэхэд:

1. Гаднаас орохыг хязгаарлах
2. Дотоод үүсэлтийн шалтгааныг багасгах
3. Инсулин глюкозтой хийх
4. Хүчилжүүлэх чанарын уусмал сэлбэх
5. Инсулин дангаар нь хийх

/124./ Бөөрний дутагдалтай өвчтөнд:

1. Катаболик стресс нь сийвэнгийн К-ийг эрс ихэсгэж болно
2. Гипермагниземи болсноос булчин сулруулагч хүчтэй үйлчилж болно
3. Үнхэлцэгт нь шингэн хуралдсан байж болно
4. Гастрины хэмжээнд өөрчлөлт орохгүй
5. Гиперкальцеми нь хоёрдогч гиперпаратиреоидизм үүсгэдэг

/125./ Пульсгүй цахилгаан идэвх(ПгЦИ)-ийн эмчилгээнд:

1. Шахсан пневмотораксын хийг зүү хатгаж гаргах
2. Эпинефрин хийх
3. Цусны эзлэхүүн нөхөх (volum resuscitation)
4. Хүчилтөрөгч өгөх
5. Дефибрилляц

/126./ Уушгины хавангийн үед илрэхгүй шинж

- A. Тахикарди
- B. Тахипноэ
- C. Хөөсөрхөг цэр гарах
- D. Склерт цус харвах
- E. Хүзүүний вен өргөсөх, цианоз

/127./ Натри илүүдсэн үед гарахгүй шинж:

- A. Гипертерми
- B. Цангах
- C. Ухаан балартах
- D. Таталт
- E. v

/128./ Эндотрахеал гуурсны жийрэгний хийн даралтаар салст дарагдаж цусан хангамж тасалдаж болох даралт (ммHg):

- A. 5
- B. 10
- C. 15
- D. 20
- E. 30

/129./ Эндотрахеал гуурсын хийлэх жийргийг аспирац ба холголт үүсгэхгүйгээр хийлэх тохиромжтой даралтын хэмжээ хэд вэ?

- A. 5 ммHg
- B. 20ммHg
- C. 40ммHg
- D. 60ммHg
- E. 80ммHg

/130./ Верапамил:

- A. Суправентрикуляр тахикарди эмчлэхэд их үр дүнтэй
- B. Астматай хүнд цээртэй
- C. Пропранололтой хавсарч өгвөл илүү сайн
- D. Хүчтэй судас нарийсгагч
- E. Сэдээгч (пейсмейкер) эсэд нөлөөлдөггүй

/131./ Зүүн ховдлын дараах ачаалал (after load) нь:

- A. Зөвхөн аортын хавхлагаас хамаарна
- B. Том артеруудын сунамхай чанар, агшилтын хүчнээс
- C. Артерийн дундаж даралтаас тооцоолон гаргаж болно
- D. Судас өргөсгөгч хэрэглэхэд нэмэгдэнэ
- E. Ховдолд урсан орох эргэлтийн цусны эзэлхүүнээс

/132./ Дефибрилляц хийхэд хамгийн дөхөмтэй хариултуудыг сонгоно уу:

- A. Зүрх зогссон тохиолдол бүрд хийнэ
- B. Бүх өвчтөнд 400J (Жоуль) хүчээр хийнэ
- C. Тодорхойгүй (гэрчгүй) тохиолдолд зүрх зогсоход
- D. Хүүхдийн ховдлын жирвэлзлийн үед анх 200J (Жоуль) хүчээр цохиулна
- E. 3 дэх оролдлогоо хийж байгаа бол 360J-аар цохиулна

/133./ Бодисын солилцооны ацидозын шалтгаан болохгүй нь

- A. Даршилсан цус их хэмжээгээр сэлбэх
- B. Цусанд кетохүчил их хэмжээгээр орох
- C. Гипокси
- D. Глюкозын уусмал сэлбэх
- E. Бөөрний дутагдал

/134./ Нитропруссид:

- A. Зөвхөн вен өргөсгөгч
- B. Өвчтөн урд нь пропранолол хэрэглэж байсан бол нитропруссидийн тунг нь ихэсгэж хэрэглэнэ
- C. Их тун нь цианидийн хордлого болгоно. Алкалозын үед адил үр дүн олохын тулд их тун хэрэглэх ёстой
- D. Хордлогын үед ацидоз үүсгэнэ
- E. Ацидозын үед хөдлого нэмэгдэх ба бикарбонат хийхэд засарна

Хариу: (D)

/135./ Амьсгалын цочмог дистрестэй өвчтөнд PEEP аргачлалыг хэрэглэхэд:

- A. Уушгины нийт ус багасна
- B. Уушги тэлэлт сайжирна
- C. Уушги доторх шунт (алгасал) багасна
- D. Цулцангийн хэт тэлэлт буурна
- E. Артерийн хүчилтөрөгчжилт ихэснэ

/136./ Гепарин цусны бүлэгнэлтийг саатуулахад оролцдог механизм:

- A. Кальцийн ион нэгдүүлж
- B. Протаминтай харилцан үйлчилж
- C. Антитромбин III-ыг идэвхжүүлж
- D. Плазминыг идэвхжүүлж
- E. Уиллибрандын факторыг идэвхжүүлж

/137./ Дараах шингэнүүдээс аль нь усыг илүү нөхөх вэ?

- A. Натри хлоридын изотоник уусмал /200мл/
- B. Рингер локкын 200 мл уусмал
- C. 200 мл желатиноль

- D. 10% глюкоз ба фруктозын уусмал /100мл/
E. Полиглюкин
- /138./ Амьсгалын замын эсэргүүцэл:
A. Терминал бронхоолд хамгийн их
B. Сурфактантын нөлөөгөөр багасна
C. Уушгины фиброзын үед ихэснэ
D. Вентиляцын хуваарилалтыг тодорхойлно
E. Анафилаксийн үед ихэснэ
- /139./ Уушгины параметруудээс хагалгааны дараах хүндрэлийн хувьд хамгийн чухал нь:
A. Амьсгалын эзлэхүүн
B. Амьсгал оруулалтын нөөц багтаамж
C. Амьдралын багтаамж
D. Үйлийн үлдэгдэл багтаамж (FRC)
E. Амьсгал оруулалтын багтаамж
- /140./ Добутамин:
A. α -адренагонист үйлдэлтэй
B. β -адрен үйлдэл давамгайл
C. Бөөрний цус эргэлт бууруулна
D. Зүрхний цохилт ихээхэн олшруулна
E. Байгалийн гаралтай катехоламин
- /141./ Кальцийн ион нь:
A. Миокардын агших чадавхийг бууруулдаг
B. Систол үргэлжлэх хугацааг багасгана
C. Судасны чангарал (тонус)-ыг багасгана
D. Ховдлын автоматизмыг бууруулна
E. Зүрхний эсэд нэвтэрч сэрэх чанарыг нэмэгдүүлнэ
- /142./ Өндрөөс унаж тархи нь гэмтсэн, тархины үхэл оношлогдоод эрхтэний “өглөгт” бэлтгэгдэж байгаа хүний шээс их, гипотензитэй байна. Цусны Na-159мэкв/л, K-3.9мэкв/л, үлдэгдэл азот (BUN)- 32мэкв/л, креатинин 1.9мг/дл, сийвэнгийн осмос 320мосм/л, шээсний осмос 250мосм/л байна. Эмнэлзүйн энэ байдал юунаас үүссэн бэ?
A. Чихрийн диабет
B. Их цус алдалт
C. Бөөрний чихэргүй диабет
D. Антидиуретик даавар дутах хамшинж
E. Төвийн гаралтай чихэргүй диабет
- /143./ Кали дутагдлын шалтгаанд орохгүйг заа:
A. Полиури
B. Кали бага авах
C. Бөөлжилт
D. Арьсаар ус алдах
E. Гэдэсний цоргоор шингэн алдах
- /144./ Цахилгаан цохилтын эмчилгээнд засрахгүй (заалтгүй) хэм алдалт:
A. Ховдлын тахикарди
B. Ховдлын жирвэлзэл
C. Тосгуурын жирвэлзэл
D. Суправентрикуляр тахикарди
E. Зүрхний бүрэн хориг
- /145./ Цусны карбоксигемоглобин 50% болсон өвчтөний неврологийн үндсэн шинж:
A. Толгой өвдөх
B. Дотор муухайрах
C. Ухаан самуурах
D. Кома
E. Үхэх
- /146./ Асцит:
A. Үүдэн венийн даралт багатай архаг өвчинд

- В. Гиперальбуминемийн үед
- С. Голдуу гипернатриемитэй хамт тохиолдоно
- Д. Зүрх, уушгины системд сөрөг нөлөө үзүүлдэг
- Е. Дахин үүсгэхгүйн тулд түргэн суллах хэрэгтэй

/147./ Хамрын гуурсаар 4л/мин хүчилтөрөгч өгч байхад FiO_2 ойролцоогоор байх нь:

- А. 24%
- В. 26%
- С. 30%
- Д. 32%
- Е. 36%

/148./ Допамин:

- А. Зөвхөн төв мэдрэлийн медиатор (трансммиттер)
- В. Зөвхөн 10мкг/кг/мин тунгаар хийхэд л допамин урвалт авуурыг сэдээнэ
- С. Бөөрний цус эргэлт муутгана
- Д. β_1 -адрен авуур сэдээж зүрхний түрэлт ихэсгэнэ
- Е. Уушгины артерийн даралт бууруулна

/149./ Тархины битүү, хүнд гэмтэлтэй хүний тархины ховдлын даралт 28ммHg байв. Эмчилгээний жагсаалтаас хасвал зохих заалт нь:

- А. Гипервентиляц
- В. Маннитол хийх
- С. Гипотерми
- Д. Тархи-нугасны шингэнд гаргуур тавих
- Е. Толгой доошлуулж хэвтүүлэх

/150./ Хагалгаа тойронд бөөрний дутал болгох осолгүйг нь заа:

- А. Гиперволеми
- В. Чихрийн диабеттай
- С. Амикацин эмчилгээ
- Д. Үжил
- Е. Хоруу гипертензи

/151./ Бөөрнөөс өмнөх шалтгаантай бөөрний дутлын үед шээс:

- А. Шингэрсэн
- В. Өтгөрсөн
- С. Хувийн жин 1010 орчимтой
- Д. Их хэмжээтэй гарна
- Е. Улаан цогцос холилдсоноос улбар өнгөтэй

/152./ Өвчтөнийг 100% хүчилтөрөгчөөр амьсгалуулж байхад үүсэх байдал:

- А. Ателектаз устана
- В. Гэдэс дүүрэлт багасна
- С. Үхмэл зай ихэссэнээр PO_2 ихэснэ
- Д. Уушгины вентиляц/ перфузийн (V/Q) харьцаа бага байгаа хэсэгт шунт үүснэ
- Е. Үйлийн үлдэгдэл багтаамж (FRC) ихэссэнээс хүчилтөрөгчийн даралт ихэснэ

Хариу: (D)

/153./ Эмийг хэлэн дор тавихад:

- А. Амаар ууснаас эмийн түвшин бага
- В. Ионжсон эмүүд илүү үйлчилнэ
- С. Анхны алгасах үр дүн гарна
- Д. Элгэнд эм түргэн задарна
- Е. Үр дүн гаргахад илүү тун шаардана

/154./ Маннитол:

1. Түүдгэнцэрт шүүгдэнэ
2. Осмосын диуретик
3. Судсан доторх эзлэхүүнийг түргэн ихэсгэнэ
4. Цусны эзлэхүүнд нөлөөлөхгүй
5. Зогсонги дутлын үед үр дүн багатай

/155./ Синусийн брадикарди нь:

1. Мэдээгүйжүүлгийн үед илэрвэл ноцтой хэм алдалтад тооцогдоно
2. Хэм алдалттай (аритми) байдаг
3. Заавал эмчилгээ шаардана мэдээгүйжүүлгийн өмнө
4. Минутанд 40-60 цохилтоор илэрнэ
5. Хүнд өвчтөний брадикардийг эмаар засах шаардлагагүй

/156./ Төв венийн гуурсны халдвараас сэргийлэхэд:

1. Гүрээний венийн гуурснаас эгэм дорх вен бага халдварлагдана
2. Повидон иод (Betadine)-оос хлоргексидин сайн
3. Гуурс тавихдаа ариун халад бээлий өмсөх
4. Хатгах хэсэгтээ бетадины түрхлэг хэрэглэх
5. Эдгээр бүгд зөв

/157./ Зүрхний гаралтай уушгины хавангийн үед яаралтай хийх эрчимт эмчилгээ нь:

1. Морфин хэрэглэх
2. Хүчилтөрөгч эмчилгээ
3. Гормон хэрэглэх
4. Лазикс хэрэглэх
5. Вазодилататор эмүүд хэрэглэх

/158./ Хийн алкалозын үед илрэх шинжийг заа:

1. Захын судасны спазм
2. Артерийн даралт буурах
3. Булчингийн таталт ба тремор
4. Тархины болон титэм судас өргөсөх
5. Оксигемоглобины диссоциац сайжирна

/159./ Циррозоос үүссэн асцит эмчлэх:

1. Аспирин өгөх
2. Спиринолактон өгөх
3. Индометацин өгөх
4. Натри хязгаарлах (багасгах)
5. Каптоприл өгөх

/160./ β 2 адрен авуурт сонгомол сэдээх (агонист) үйлдэлтэй эмүүд:

1. Метапротеренол
2. Изоэтарин
3. Альбутерол
4. Метопролол
5. Эдгээр бүгд

/161./ Төв венийн даралт зөв тодорхойлоход:

1. Гуурсны үзүүр хөндий венийн цээжний хэсэгт байвал болно
2. Гуурсны үзүүр хөндий вен тосгуурт орох хэсэгт байвал болно
3. Даралт амьсгалын хөдөлгөөнөөр хэлбэлзэж байх ёстой
4. Гуурснаас соруулахад цус гарч байх
5. Даралт хувиргагч баруун тосгуурын түвшинд байх

/162./ Цочмог деструктив панкреатитын эмчилгээний ерөнхий зарчим:

1. Шок, гиповолемийг эмчлэх
2. Амьсгалын алдагдлыг эмчлэх
3. Ус электролитийн баланс, хүчил суурийн алдагдлыг засах
4. Өвдөлт намдаах
5. Ходоод гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг хэвийн болгох

/163./ РЕЕР-ийг хэрэглэх үед тохиолдож болох нь:

1. Үйлийн үлдэгдэл багтаамж (FRC)-ийг багасгана
